



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэгдүгээр хавсралтад заасан нийт 19,650,000.00 (арван есөн сая зургаан зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ, 16,786,666.00 (арван зургаан сая долоон зуун наян зургаан мянга зургаан зуун жаран зургаан) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 нэрийн хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн 0286 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хоёрдугаар хавсралтад заасан нийт 870,088,771.00 (Найман зуун далан сая наян найман мянга долоон зуун далан нэгэн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 нэрийн хөрөнгийг ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн “Тайшир-Гуулин” усан цахилгаан станц хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн 0286 дугаар ангийн захирагч, дэд хурандаа М.Эрдэнэбуян, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Бадамсүрэн, “Алтай-Улиастайн” эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн “Тайшир-Гуулин” усан цахилгаан станц хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Амартүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны ... дүгээр сарын ... өдрийн
 ... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХИЛИЙН 0286 ДУГААР АНГИД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хөрөө ирлэх машин	31.07.2016	ш	1	2,200,000.00	1,081,666.00	1,118,334.00
2	Трактор FOTON FT-240 хадууртай	30.11.2012	ш	1	17,450,000	15,705,000.00	1,745,000.00
	Нийт дүн				19,650,000.00	16,786,666.00	2,863,334.00
						(арван зургаан сая долоон зуун наян зургаан мянга зургаан зуун тавин мянга)	(хоёр сая наян зургаан мянга гурван зуун гучин дөрөв)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дүгээр сарын 22 өдрийн
403 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ	Ашиглах хугацаа /жил/	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Турбинно генераторнын систем 6,3 кВт №1	2011	435,044,385.49	15,000,000.00	20	"Алтай-Улиастайн ЭХС" ТӨХК-ийн "Тайшир-Гуулин" усан цахилгаан станц ХХК
2	Турбинно генераторнын систем 6,3 кВт №1	2011	435,044,385.49	15,000,000.00	20	
			870,088,771.00	30,000,000.00		
	Нийт дүн		(Найман зуун далан сая наян найман мянга долоон зуун далан нэг)	(гучин сая)		